

АЗИ НОМХОН ДАЛАЙН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР, БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦ БА МОНГОЛ УЛС

Товч судалгаа

СИТИ Их сургуулийн багш, эдийн засгийн ухааны магистр Лодойдамбын Галбадрах

Э-мэйл: lodgal3211@yahoo.com

Хүлээн авсан 2023.09.05, Засварласан 2023.09.20, Хэвлэлтэнд авсан 2023.09.25

Хураангуй

Ази Номхон далайн бүс нутагт Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) нь худалдаа хөрөнгө оруулалтын бодлого, эдийн засгийн интеграцын чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна.

Монгол Улс бүс нутгийн чөлөөт худалдааны сүлжээнд нэгдэн орсноор бүсийн хэмжээний эдийн засгийн интеграцад орох боломж буй болж бараа, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар, технологи, иновацийн чадамж нэмэгдэхээс гадна хөдөлмөрийн хуваарийн дагналт хийгээд урт хугацааны бизнесийн өгөөж, олон улсын хөрөнгө оруулалт, технологийн дамжуулалт өсч, худалдааны дүрэм хялбаршин элдэв хориг арга хэмжээ арилах сайн талтай.

Монгол Улс олон чиглэлээр нэгэн зэрэг интеграцид орох их нөөц бололцоотой гэж үзэж байна. Бидний байгалийн баялгийн нөөц хийгээд газар зүйн байрлал тухайлбал, хоёр том зах зээлийн дунд оршдог нь боломж болно.

Түлхүүр үг: Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ); Номхон далайн түншлэлийн хэлэлцээр (ТРР), Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (RCEP); Зүүн Өмнөд Азийн орнуудын Холбоо (АСЕАН)



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2024 Author(s)

Оршил

Монгол улсын гадаад бодлогын чиг баримжааны үндсэн баримт бичигт “*XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна*” гэж заасан байна [1]. Өнөөдөр даяаршил хийгээд үндэсний эрх ашиг түүнчлэн гадаад худалдааны либералчлал болон үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого зэргийн уялдаа агаад зөрчлөөс үүдэн багагүй сорилттой тулгарч буй авч Ази Номхон далайн бүс нутагт Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) нь худалдаа эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна. Өдгөө тус бүс нутагт олон талт ба хоёр талын нийт 80 орчим ЧХХ үйлчилж байгаа төдийгүй нилээд олон хэлэлцээр байгуулагдах шатандаа явж байна. Бүс нутгийн улс орнууд өөрийн орны эдийн засгийн хөгжлийн онцлог, гадаад худалдааны экспорт, импортын бүтэц хийгээд голлох түнш, тэдний байр суурь зэрэгтэй уялдуулан Номхон далайн түншлэлийн хэлэлцээр (TPP, Trans-Pacific Partnership), Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (RCEP, The Regional Comprehensive Economic Partnership), Ази Номхон далайн чөлөөт худалдааны хэлэлцээрийн асуудалд хандаж ирсэн онцлогтой.

Номхон далайн түншлэлийн хэлэлцээр (TPP), нь олон улсын эдийн засгийн харилцаан дахь томоохон цар хүрээг хамарсан хэлэлцээрийн нэг гэж үздэг бөгөөд нэгдэн орсноор гишүүн орнуудад экспортын хөнгөлөлт эдлэх, хөрөнгө оруулагч талуудын маргаан шийдвэрлэх системд хамрагдах боломж бүрдэх түүнчлэн эл Хэлэлцээрт гарын үсэг зурах нь бүс нутгийн худалдааны либералчлалыг дэмжиж буйн илрэл болох чухал ач холбогдолтой гэсэн байр суурийг гишүүн орнууд баримталж ирсэн аж.

TPP-ээс гадна түүнтэй зэрэгцэн ирсэн АСЕАН-ы гишүүн орнууд Бруней, Камбож, Индонез, Лаос, Малайз, Мьянмар, Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам түүнчлэн Австрали, Хятад, Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос, Шинэ Зеланд зэрэг 6 улс багтаж байгаа Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (RCEP)-ийн эхлэл 2012 оны 11-р сард Камбожид болсон АСЕАН-ы Дээд хэмжээний уулзалт дээр албан ёсоор тавигджээ. Нээлттэй эх сурвалжид мэдээлснээр “*2022 оны байдлаар 3.4 тэрбум хүн ам, 49.5 их наяд ам.доллартай тэнцэх ДНБ (GDP) тус RCEP-ийн гишүүн орнуудад хамрагдаж байна.*” [2]. Эдийн засгийн талаасаа RCEP илүү ашигтай хэдий боловч дээрх хоёр хэлэлцээр нь бие биеэ үгүйсгэхгүй, харин ч нөхөх агаад улс орнуудад илүү чөлөөтэй худалдаа хийх давхар боломж бүрдүүлж байна хэмээн АСЕАН-ы ихэнх гишүүн орнууд үзэж байгаа бололтой.

Зүүн Өмнөд Азийн орнуудын Холбоо (АСЕАН) (англиар- Association of South East Asian Nations) — Зүүн Өмнөд Азийн 10 орны Засгийн газар хоорондын улс төр, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны бүс нутгийн байгууллага. Бангкок хотноо 1967 оны 8 дугаар сарын 8-нд тухайн үеийн таван орны Гадаад хэргийн сайд нар Индонезийн

Адам Малик, Малайзийн Абдул Разак, Сингапурын С.Раджаратнам, Тайландын Танат Кхоман, Филиппины Нарцисо Рамос нар “АСЕАН-ны Тунхаглал”-д гарын үсэг зурснаар АСЕАН бий болсон хэмээн үздэг. \”Бангкокийн Тунхаглал” гэдгээр нь олон нийт судлаачид илүү мэддэг/.Тухайн орнууд бүс нутагт Коммунизм дэлгэрэх айдас, бүс нутагт ноёрхлоо хадгалах бодлого явуулж байсан их гүрнүүдэд итгэхгүйд хүрсэн, тогтвортой байдлыг хүссэн, эдийн засгаа хөгжүүлэх сонирхол өндөр байсан зэргийг судлаачид АСЕАН үүсэн байгуулагдсан үндсэн шалтгаан гэж үздэг. АСЕАН-ны урьтал бол 1961 онд байгуулагдсан Филиппин, Малайз, Тайландыг нэгтгэсэн Зүүн Өмнөд Азийн Холбоо /ASA/ нэртэй байгууллага байсан. Индонезийн Бали арал дээр1976 онд болсон анхны дээд хэмжээний уулзалтын үеэр Зүүн Өмнөд Ази дахь найрамдал, хамтын ажиллагааны болон АСЕАН-ны Тунхаглалын тухай Гэрээ байгуулснаар уг байгууллагын эрх зүйн үндсийг тавьжээ.

Дараа нь 1984 оны 1 дүгээр сарын 7 -нд Бруней-Даруссалам, Вьетнам1995 оны 7 дугаар сарын 28-нд, Лаос, Мьянмар 1997 оны 7 дугаар сарын 23-нд, сүүлд Камбож 1999 оны 4 дүгээр сарын 30-нд нэгдсэнээр АСЕАН 10 гишүүн орноос бүрддэг болсон түүхтэй. 2002 онд Зүүн Тимор ажиглагч болох хүсэлт гаргасанаар Папуа шинэ Гвиней, Зүүн Тимор хоёр улс АСЕАН-ны ажиглагчийн статустай байна.

АСЕАН-ны гишүүн орнуудын нийт газар нутаг 4.4 сая ам дөрвөлжин км. Мөн гишүүн орнуудын нийт хүн ам нь 625 орчим /2016 оны байдлаар/ сая хүн буюу дэлхийн нийт хүн амын 8,8% эзэлж байна.



Fig.1. Asian countries in the World state map. Adapted from reference [2].

АСЕАН бол барааны, үйлчилгээний, хөрөнгө оруулалтын, хөрөнгийн болон ажиллах хүчний чөлөөт солилцоо бүхий „ASEAN Economic Community“ (AEC) буюу эдийн засгийн нэгдмэл бүс байгуулахаар ажиллаж байгаагаас гадна хил дамнасан зам тээврийн болон эрчим хүчний “Их Меконгийн дэд бүс” зэрэг өргөн далайцтай төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Түүнчлэн санхүү, валютын интеграцын нэлээд зүгширч буй эхлэл болох Chiang Mai Initiative Multilateralisation (CMIM) гэх зэрэг

нь валютын ханшийн ноцтой хэлбэлзлээс урьдчилан сэргийлэх хяналтын механизмын зэрэгцээ их хэмжээний хөрөнгийн нөөцийг бүрдүүлсэн санхүүгийн ба валютын интеграцийн дэвшилтэй хандлага учраас энэ нь яваандаа Азийн валютын сан болон хөгжих ирээдүйтэй гэж үзнэ. Энэ тал дээр АСЕАН-ы “өргөтгөл” буюу АСЕАН+3 гэх арга хэмжээний хүрээнд БНХАУ, Өмнөд Солонгос болон Япон Улс нааштай хандаж байгаагийн гадна чөлөөт худалдааны хэлэлцээрийн сүлжээгээрээ дамжуулан дэлхийн хамгийн том чөлөөт худалдааны бүс болох тууштай зам дээр байна гэж дүгнэж болно. Ингэснээр энэ эвсэл Зүүн Азийн түлхүүр байгууллага болон хөгжих боломжтой.

АСЕАН+3 нь үр дүнтэй интеграцын үйл явцын катализатор болох ирээдүйтэйгээс гадна бүс нутгийн улс төрийн маргааныг зохицуулах (одоохондоо бүрэн ашиглаагүй) потенциалтай агаад АСЕАН+3 механизм нь тухайн улс өөрийн сонирхолоо хамгаалахад тогтвортой түшиг тулгуур болох боломжтой.(Энэ нь тухайлбал Филиппин Улс болон БНХАУ-ын хоорондох газар нутгийн маргаан дээр тод харагдсан). Энэ бүхэн бол АСЕАН+3 нь Монголын хувьд бүс нутгийн интеграцийн үүднээс илүү оновчтой байж болохыг харуулж буй үнэмшилтэй нотолгоо.




Fig. 2. ASEAN+3: AMRO Growth Estimates and Forecasts, 2023-2024

(Percent year-on-year) Note: e = estimates; f = forecast. Regional aggregates for growth are estimated using the weighted average of 2021 GDP on purchasing power parity basis; <https://amro-asia.org/asean3-regional-economic-outlook-2023-in-five-charts/>, Adapted from reference [3]

Социалист лагерь 1990-ээд онд нуран унаж олон улсын байдалд гүнзгий өөрчлөлтүүд гарсанаар АСЕАН гишүүдийн эгнээгээ тэлэн өргөжүүлэх, цаашид хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх сонирхол нь улам идэвхижсэн. 1990 онд бүс нутагт АНУ-

ын бүх талын нөлөөг сулруулах зорилгоор Малайз Улсын зүгээс АСЕАН-ны гишүүн орнууд дээр БНХАУ, Япон, Өмнөд Солонгосыг нэгтгэсэн “Зүүн Азийн Эдийн засгийн Зөвлөл” /East Asia Economic Caucus/ байгуулах санал дэвшүүлсэн байдаг. Гэвч АНУ, Японы эсэргүүцэлтэй тулгарч санаачилга мухардалд орсон боловч гишүүн орнууд санаагаа орхилгүй хөөцөлдсөний дүнд 1997 онд зүүн Азийн эдийн засгийн хямралын дараагаар Малайзын дээр дурдсан санаачилга Чиангмай-д сэргэж АСЕАН болон АСЕАН+3 /Хятад, Япон, Өмнөд Солонгос/ хоорондох эдийн засгийн интеграцлалыг гүнзгийрүүлэхэд чиглэсэн Чиангмайн санаачилга /Chiang Mai Initiative/ “АСЕАН + 3” "ASEAN Plus Three" гэсэн ойлголт бий болсон [4].

Монгол Улс газар зүйн байршлаараа бол Өмнөд Азийн орон биш гэдэгтэй маргах аргагүй. Үүнээс гадна дээр дурдсанчлан АСЕАН-ы интеграц нэлээд их урагшлан хөгжчихсэн байгаа. Гэлээ ч гэсэн Монгол Улсын хувьд Зүүн Өмнөт Азийн АСЕАН+ томьёоллын дараачийн орон болж нэгдэх боломжийг сүвэгчлэн хайж, нухацтай авч үзэх, өөрөөр хэлбэл, АСЕАН+3 томьёоллыг өргөтгөн АСЕАН+4 болгохыг хичээх шаардлагатай байна. Үүний тулд Монгол Улс АСЕАН+3 –ын бэлхэнээ хэрэгжүүлсэн интеграцийн дэвшлийг нөхөж гүйцэх буюу түүнд элсэн орох интеграцын гэрээгээр тавигдах шаардлага, шалгууруудыг аль болох хангахад ирээдүйн бодлогоо чиглүүлэн ажиллах хэрэгтэй. Энэ үүднээс Монгол Улс одоогийнхоосоо илүү тууштайгаар өөрийн эдийн засгийн үйл ажиллагаа болон гадаадын хөрөнгө оруулалтын орчинг үлэмж сайжруулах, ялангуяа хууль эрх зүйн тогтвортой байдлыг хангах, хүнд суртлыг арилгах, худалдааны хөнгөлөлт, эрчим хүчний хангалт, зам тээврийн дэд бүтэц зэргийг сайжруулах болон иргэдийнхээ боловсролыг дээшлүүлэхэд гойд анхаарах шаардлагатай нь ойлгомжтой юм. Иймд юуны өмнө бид АСЕАН-ы гишүүн орнууд голлон санаачилсан бөгөөд цөмийг нь бүрдүүлж байгаа Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (RCEP)-т нэгдэн орох нь зүйтэй гэж үзэж байна.

АСЕАН нь гишүүн орнуудынхаа эдийн засгийн хөгжил, интеграцлалыг чухалчилахаас гадна бүс нутгийн энх тайван, тогтвортой байдалд багагүй анхаарч ирсэн. Зүүн Өмнөд Азийн бүс нутгийг цөмийн зэвсэгээс ангид байлгах үүднээс 1995 оны 12 дугаар сарын 15-нд “Цөмийн зэвсэгээс ангид бүс байгуулах Зүүн Өмнөд Азийн Гэрээ”-нд /Southeast Asian Nuclear-Weapon-Free Zone Treaty / гишүүн орнууд гарын үсэг зурсан.

Үүнээс гадна дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа байгаль хамгаалах, ногоон орчин зэрэг үйл хэрэгт өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж ирсэн НҮБ өөрийн Ерөнхий Ассамблейд оролцох ажиглагчийн статусыг 2006 онд АСЕАН-д, харин АСЕАН “яриа хэлэлцээний түнш”-ийн статус НҮБ-д олгосон байна

Азийн хөгжлийн Банкны судалгаанаас харахад 2021 оны байдлаар Ази номхон далайн орнуудын гадаад худалдаанд ХАА-н бүтээгдэхүүний хувьд 46% нь бүрэн, 28% нь хэсэгчилсэн хэлбэрээр, мөн үйлдвэр үйлчилгээний 41% нь бүрэн, 25% нь ямар нэг хэмжээгээр ЧХХ-т хамрагджээ [5].

Монгол Улс бүс нутгийн чөлөөт худалдааны сүлжээнд нэгдэн орсноор жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх, түүнд хөдөө аж ахуйг

илүү түлхүү хамруулах, худалдаа үйлчилгээний либералчлалыг нэмэгдүүлэх чингэснээр бүсийн хэмжээний нэгдсэн эдийн засгийн интеграцад орох боломж буй болж бараа, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар, технологи, иновацийн чадамж нэмэгдэхээс гадна илүү өргөн зах зээл нээгдэнэ. Түүнчлэн хөдөлмөрийн хуваарийн дагналт хийгээд урт хугацааны бизнесийн өгөөж өсөх, олон улсын хөрөнгө оруулалт, технологийн дамжуулалт, нутагшуулалт хийгдэн худалдааны дүрэм хялбаршин элдэв хориг арга хэмжээ арилах сайн талтай гэж юм. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон мөртлөө Монгол Улс одоогоор Японоос өөр ямар ч улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулаагүй байгаа цорын ганц улс бөгөөд \Өнөөгийн байдлаар БНСУ-тай ЧХХ байгуулахаар судалгааны ажил, хэлэлцээ хийж байна\ энэ нь юуны өмнө Зүүн Азид улам бүр нэмэгдэж буй чөлөөт худалдааны олон улсын хэлэлцээрүүдийн олон улсын хэлэлцээр “Noodle Bowl” гэгчийн [3] дундах нэгэн онцгойрол болон харагдаж байгаа нь нууц биш юм. Харин интеграцийн ямар хэлбэрийг Монгол Улс тэргүүн эгнээнд хэрэгжүүлэх ёстой вэ гэдэг асуулт нэлээд эрсдэлтэй байгаа. Эдийн засгийн чухал түншүүдтэйгээ хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээрийн сүлжээ байгуулах гэж чармайх нь бидний хувьд тийм ч зөв зүйл биш гэж үзнэ. Учир нь Монгол Улс зөвхөн ашигт малтмал дээр суурилсан, жижигхэн бөгөөд сулхан хөгжсөн эдийн засагтай орны хувьд БНХАУ, ОХУ зэрэг өөрийн шууд эдийн засгийн хамаарал бүхий улсуудтай яриа хэлэлцээ хийхэд анхнаасаа л сул дорой байр суурьтай байх магадлалтай.

Номхон далайн түншлэлийн Хэлэлцээр (TPP)-ийн хувьд хоёр тивийг хамарсан эвслийн оролдлогуудын интеграцийн нөлөө одоо хүртэл тун чамлалттай байгаа бөгөөд ойрын үед өөрчлөгдөх магадлал маш бага байна. Тэгээд ч TPP-д Хятад, Солонгос болон Орос байхгүй үүнээс гадна АНУ уг хэлэлцээрээс гарсан зэрэг нь ирээдүйг нь улам бүрхэг болгож байна. Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага АПЕК-т (Asia-Pacific Economic Cooperation, АРЕС) гишүүнээр орох магадлал Лаос, Камбож, Мьянмар зэрэгтэй харьцуулбал Номхон далайн гарцаас алс хол, өөр интеграцын сүлжээнд хамрагдаагүй Монголын хувьд тун бага юм.

Харин зөвхөн Европын Холбоо ч биш, сүүлийн үед маш амжилттай хөгжиж байгаа Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН) бол баялгийн хуваарилалт болон нийгэм эдийн засгийн хөгжлийг хөхүүлэн дэмжих нөлөө бүхий бүс нутгийн интеграцийн тод жишээ юм. Учир нь ийм интеграц бол оролцогч талууд зах зээлдээ харилцан нэвтрэх боломжийг нь нэмэгдүүлэн аж үйлдвэрийн болон эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэлийг эрчимжүүлж, санхүүгийн ба хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэрийг нээж өгдөг. Үүгээрээ уг бүс нутгийн орнуудын хөгжлийн янз бүрийн хурдацыг уялдуулахад тус дөхөм болж байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

Монгол Улс олон чиглэлээр нэгэн зэрэг интеграцид орох маш их нөөц бололцоотой гэж үзэж байна. Бидний байгалийн баялгийн нөөц хийгээд газар зүйн байрлал тухайлбал, зөвхөн хоёрхон хөрштэй буюу хоёр том зах зээлийн дунд оршдог оос гадна шууд хиллэдэг гуравдах хөршгүй болон далайд гарцгүй нөхцөл байдлыг харин ч бүр боломж бололцоо хэмээн авч үзэж болно.

Монгол Улсын эдийн засагт ойрын ирээдүйд шийдвэрлэх чухал нөлөөтэй гэж үзэхүйц байгалийн баялгаа боловсруулан борлуулахын тулд амархан хүрч болохуйц зах зээл хэрэгтэй байгаа. Монголын түүхий эдийн баялгийг худалдан авах сонирхол зөвхөн АНУ болон ЕХ-оор хязгаарлагдахгүй юм. Хамгийн сонирхолтой борлуулалтын зах зээл гэвэл ирэх жилүүдэд эдийн засгийн хөгжлийн өсөлтөөр АНУ болон ЕХ-ноос ч илүү байх өндөр магадлалтай бөгөөд бидний хувьд “хамар хашаагаа” тойроод л хүрэхүйц, зам тээврийн хувьд ойр дөт орших Япон, Өмнөд Солонгос, АСЕАН-ы орнууд болон ялангуяа Хятад Улсыг багтааж буй бүс нутаг юм. Бас нэг өөр аспект бол Монгол Улс бол зүйн хувьд Зүүн Хойт Азийн төвд байрлалтай , өөрөөр хэлбэл зүрхэнд нь оршдог бөгөөд үүгээрээ Оросын түхий эдийн болон эрчим хүчний зах зээлийг Хятадын аж үйлдвэрлэлээс өргөн хэмжээгээр зааглахаас гадна (Хятад улс бол Оросын хувьд эдүгээ худалдааны хамгийн том түнш болон хувираад байгаа) бас Хятадын аж үйлдвэржсэн зүүн хойд мужууд болон харьцангуй бага нээгдсэн баруун хойд мужуудын хооронд газар зүйн хувьд зааглах буюу нөгөө талаас авч үзвэл гүүр болох байрлалтай юм.

Мэдээж хэрэг, одоохондоо Монгол Улсад тээврийн болон эрчим хүчний дэд бүтцийн шинэчлэл болон өргөтгөлд хэрэгцээтэй хөрөнгө дутагдаж байгаа. Гэхдээ эцсийн дүндээ бүс нутгийн интеграцчилал л Монголын ирээдүйд эдийн засаг, улс төрийн нэн чухал бодит боломжуудыг буй болгоно гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, <http://nda.gov.mn/backend/f/2xkJuDjl48.pdf>
2. Asia’s Free Trade Agreements, How is Business Responding?, Editors: Masahiro Kawai and Ganeshan Wignaraja, Edward Elgar Publishing Limited The Lypiatts 15 Lansdown Road, Cheltenham Glos GL50 2JA, UK, p.283. 2011
3. ASEAN+3 Regional Economic Outlook 2023 in Five Charts, <https://amro-asia.org/asean3-regional-economic-outlook-2023-in-five-charts/>
4. ASEAN Key Figures 2022, <https://asean.org/book/asean-key-figures-2022/>
5. ASEAN Economic Community Blueprint Report No4, 2021, https://asean.org/wp-content/uploads/2021/08/AECBP_2025r_FINAL.pdf

ASIA-PACIFIC FREE TRADE AGREEMENT, REGIONAL ECONOMIC INTEGRATION AND MONGOLIA

Research note

Lodoidamba Galbadrach

Lecturer of CITI University, Ulaanbaatar, Mongolia

E-mail: lodgal3211@yahoo.com

Received 05.09.2023,

Revised 20.09.2023,

Accepted 25.09.2023

Abstract

Mongolia is believed to have great potential for simultaneous integration in many fields. Our natural resources and geographical location, such as having only two neighbours, being in the middle of two large markets, and having no direct border with a third neighbour and landlocked situation, can be considered an opportunity.

Mongolia's economy needs an easily accessible market to process and sell its natural resources, which are considered crucial in the near future. Interest in purchasing Mongolia's raw material wealth is not limited to the US and the EU. The most interesting sales market is that in the coming years, economic development growth will be higher than that of the USA and the EU. For us, Japan, South Korea, and ASEAN countries, which are close by road and can be reached just around our "nose fence", and especially is a region that includes China. Another aspect is that Mongolia is geographically located in the centre of Northeast Asia, i.e. in the heart of it, which not only separates Russia's raw material and energy markets from China's production (China is now Russia's largest trade partner and (which is changing) is also geographically positioned as a bridge between China's industrialised northeastern provinces and the relatively less developed northwestern provinces.

Of course, at the moment, Mongolia lacks the necessary funds to modernise and expand transportation and energy infrastructure. However, in the end, it leads to the conclusion that only regional integration will create significant real economic and political opportunities in the future of Mongolia.

Keywords: Free Trade Agreement (FTA); Trans-Pacific Partnership (TPP), Regional Comprehensive Economic Partnership (RCEP); Association of Southeast Asian Nations (ASEAN)



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2024 Author(s)